

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 15-НЫ ӨДӨР ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр, Лхагва гараг*

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	1
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	2-3
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	4-8

---

1.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 04 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	4-8
--	-----

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Төсвийн байнгын хорооны 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр  
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 18 цаг 04 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Батцэцэг, Б.Түвшин;  
Чөлөөтэй: Т.Аубакир, Ж.Баясгалан, Ж.Ганбаатар, П.Ганзориг,  
П.Мөнхтулга, Б.Чойжилсүрэн;  
Эмнэлгийн чөлөөтэй: Н.Алтанхуяг, Х.Болормаа.

**Нэг.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 04 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Татварын ерөнхий газрын Хуулийн хэрэгжилтийг хангах газрын дарга Ц.Тогосмаа, мөн газрын Татвар төлөгчтэй харилцах газрын дарга Б.Буяннэмэх, Олон улсын татварын хэтсийн дарга Л.Мөнхтуул нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Нямбаяр, А.Болортуяа, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Хуулийн төслийн 1, 2, 3 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал, зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24-т

заасны дагуу анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг гаргав.

**Ц.Даваасүрэн:** Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 3  
Бүгд: 14  
78.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Д.Цогтбаатар, Д.Батлут нарыг дэмжсэнээр тооцож, 100 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 16 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр 18 цаг 20 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**  
2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр,  
Лхагва гараг Төрийн ордон “Үндсэн хууль” танхим 18 цаг 04 минут

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

---

**Ц.Даваасүрэн:** Байнгын хорооны гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг эрье ээ.

Төсвийн байнгын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдааны ирц ирвэл зохих 25 гишүүнээс 13-ын ирц 52 хувьтай байгаа учраас хуралдааныг нээснийг мэдэгдье ээ.

Байнгын хорооны хуралдаанд ирсэн гишүүдийг би та бүхэнд танилцуулъя. Тэмүүлэн гишүүн, Мэндсайхан гишүүн, Заяабал гишүүн, Цогтбаатар гишүүн, Дамдинням гишүүн, Ганхуяг гишүүн, Батбаяр гишүүн, Ганбаатар гишүүн, Батболд гишүүн, Мөнхсоёл гишүүн, Гомбын Ганбаатар гишүүн, Батжаргал гишүүн, Батлут гишүүн нар бүртгүүлсэн байна. Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлыг та бүхэнд танилцуулъя аа.

Өнөөдрийн хорооны хурлаар нэг асуудал байна. Цэцийн 2024 оны 4 дүгээр дүгнэлттэй холбогдуулаад Татварын ерөнхий хуульд өөрчлөлт орох ёстой.

Ингээд энэ Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ ээ. Анхны хэлэлцүүлгийг. Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Алга байна.

**Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье ээ.**

ҮХЦ-ийн 2024 оны 4 дүгээр дүгнэлтийг хүлээж авсантай холбогдуулаад Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Заяабалаар ахлуулж, Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг, Б.Мөнхсоёл нар бүрэлдэхүүнд нь ажилласан байгаа.

Ингээд ажлын хэсгийн хуулийн төслийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Заяабал гишүүн танилцуулна. Заяабал гишүүн танилцуулъя.

**Б.Заяабал:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт татвар төлөгчийн татварын хууль тогтоомжийг зөрчсөн бөгөөд хууль тогтоомжид заасан хугацаанд зөрчлөө арилгагүй, нэг зөрчлийг 3 болон түүнээс дээш удаа давтан гаргасан, татвар төлөгчийн талаар Татварын алба татвар төлөгчийн зөвшөөрөлгүйгээр нийтэд мэдээлж болно гэж заасан нь Монгол Улсын үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалтад халдашгүй чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Иргэний хувийн халдашгүй байдлыг хуулиар хамгаална гэж заасныг зөрчсөн байна гэж ҮХЦ-ийн 2024 оны 11 сарын 22-ны өдрийн 0:04

дүгээр дүгнэлтийг Улсын Их Хурлаас 2024 оны 12 сарын 26-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, уг дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзэж Монгол Улсын Их Хурлын ҮХЦ-ийн 2024 оны 4 дүгээр дүгнэлтийн тухай, 2024 оны Улсын Их Хурлын 57 дугаар тогтоолыг баталсан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.3 дахь хэсэгт хууль тогтоол Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй гэсэн Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурлаас хүлээн зөвшөөрсөн бол ажлын 15 өдрийн дотор тухайн болон холбогдох бусад хууль, шийдвэрт зохих нэмэлт, өөрчлөлт оруулна гэж, мөн хуулийн 84.5 дахь хэсэгт энэ хуулийн 84.3-д заасан Хууль, тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн тухай төслийг холбогдох Байнгын хороо боловсруулж нэгдсэн хуралдаанд оруулах бөгөөд уг төслийн талаар Засгийн газар холбогдох бусад байгууллагаас санал авахгүй, авахыг шаардахгүй гэж заасан.

Иймд Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн тогтоолоор Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах Байнгын хорооны болон нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Заяабал, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Ганзориг, Мөнхсоёл нар ажилласан.

Ажлын хэсэг 2025 оны 1 дүгээр сарын 14, 15-ны өдрүүдэд тус тус хуралдаж ҮХЦ-ийн 2024 оны 4 дүгээр дүгнэлтийн үндэслэл хэсгийн хүрээнд. Энэ үндэслэл хэсэг нь нэлээн их юм байгаад байгаа шүү. Үндэслэл хэсгийн хүрээнд хуулийн төслийг боловсрууллаа.

Тодруулбал:

1.Эрх зүйн тодорхой байдлыг хангасан эсэх тухайд татварын хууль тогтоомжийг зөрчсөн байхын зэрэгцээ хууль тогтоомжид заасан хугацаанд зөрчлөө арилгаагүй, нэг зөрчлийг 3 болон түүнээс дээш удаа давтан гаргасан, эрэн сурвалжлагдаж байгаа гэсэн нөхцөл бүрдсэн бол түүний мэдээллийг зөвшөөрөлгүй нийтэд дэлгэхээр хуульчилсан нь татвар төлөгчийн хувийн мэдээлэл халдашгүй байх эрхийг хязгаарласан байна гэж үзэхээр байна аа. Чухам ямар хууль, тогтоомж ямар заалтыг зөрчсөн тохиолдолд татварын хууль тогтоомжийг зөрчсөн гэж үзэх нь тодорхойгүй байна аа. Түүнчлэн хууль тогтоомжид заасан зөрчлөө арилгаагүй гэсний зөрчил гэдэгт Татварын ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль, эсхүл хууль тогтоомжид заасан ямар нэгэн үйлдэл, эс үйлдэхүйг ойлгох, зөрчлийн мөн чанар, нийгмийн хор уршгийн хэр хэмжээг харгалзах эсэх нь тодорхойгүй байна гэсэн бол тохирсон байх зарчмыг хангасан эсэх тухайд уг зөрчил нь адил түвшний ноцтой биш байж болохыг хуулийн зохицуулалтаар хүлээн зөвшөөрсөн байна аа. Өөрөөр хэлбэл ялимгүй зөрчлийг хуулийн хугацаанд арилгаагүй зэрэг тохиолдолд тухайн татвар төлөгчийн талаар нийтэд мэдээлэх, хувийн мэдээллийг нийтэд дэлгэх замаар алдар хүндэд нь ноцтой халдах боломжтой байна аа. Энэ тохиолдолд тэнцвэртэй байх зарчим алдагдсан байна гэсэн байна аа.

Үүнтэй холбогдуулан санхүүгийн баримтыг хуурамчаар үйлдсэн эсэх нь хууль хяналтын байгууллагаар хянан шалгагдаж байгаа, хууль хяналтын байгууллагын эсвэл шүүхийн шийдвэрээр эрэн сурвалжлагдаж байгаа гэж өөрчилж тодорхой болгон тусгалаа.

2.Эрх зүйн тодорхой байдлыг хангасан эсэх тухайд нийтэд мэдээлэх мэдээллийн агуулга хүрээг тодорхой тусгаагүй. Тухайлбал татвар төлөгчийн талаар нийтэд мэдээлэх гэдэгт ямар мэдээлэл багтаж байгаа болон уг татвар төлөгчийн нэр, хүйс, хаяг, эрхэлсэн ажил, албан тушаал, зөрчил, төлөгдөөгүй өр, бусад хувийн шинжтэй мэдээлэл агуулагдах эсэх нь тодорхойгүй гэсэн бол тохирсон байх зарчмыг хангасан эсэх тухайд татвар төлөгчийн талаар ямар ч мэдээллийг нийтэд мэдээлж болохоор хэт өргөн хүрээтэй хязгаарласан нь үндсэн эрхийн хязгаарлалт явцуу хүрээтэй байх үндсэн эрхийг хамгийн бага хэмжээнд хязгаарлах зайлшгүй байх зарчимд нийцэхгүй байна гэсэн байна аа. Үүнтэй уялдуулан дээр дурдсан санхүүгийн баримтыг хуурамчаар үйлдсэн эсэх нь хууль хяналтын байгууллагаар хянан шалгагдаж байгаа татвар төлөгчийн нэр, татвар төлөгчийн дугаар, шалгагдаж байгаа асуудлын талаарх мэдээллийг олон нийтэд мэдээлэх бол хууль хяналтын байгууллагын эсвэл шүүхийн шийдвэрээр эрэн сурвалжлагдаж байгаа татвар төлөгчийн нэр, татвар төлөгчийн дугаарын мэдээллийг олон нийтэд мэдээлэх зохицуулалтыг тусгаж орууллаа.

3.Эрх зүйн тодорхой байдлыг хангасан эсэх тухайд мэдээлэх арга, мэдээллийн хэрэгслийг тодорхой тусгаагүй байна гэсэн байна аа. Үүнтэй холбогдуулан татвар төлөгчийн мэдээллийг жагсаалт хэлбэрээр татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын албан ёсны цахим хуудсанд уг зохицуулалтад хамаарах татвар төлөгчийн талаарх мэдээллийг нийтэлж, олон нийтэд мэдээлэх зохицуулалтыг тодорхой болгон тусгалаа.

4.Эрх зүйн тодорхой байдлыг хангасан эсэх тухайд мэдээлэх арга, хугацааг тодорхой тусгаагүй байна гэсэн бол тохирсон байх зарчмыг хангасан эсэх тухайд Татвар төлөгчийн талаар нийтлэгдсэн мэдээлэл бодитой үнэн зөв биш тохиолдолд мэдээлэл засвар оруулах процессын хамгаалалтыг татвар төлөгчдөд олгоогүй нь үндсэн эрхийн хязгаарлалт явцуу хүрээтэй байх үндсэн эрхийг хамгийн бага хэмжээнд хязгаарлах зайлшгүй байх зарчимд нийцэхгүй байна гэсэн байна аа. Үүнтэй холбогдуулан уг зохицуулалтад хамаарах нөхцөл бүрдсэн тохиолдолд татвар төлөгчийн мэдээллийг олон нийтэд мэдээлэхээс ажлын 10-аас доошгүй өдрийн өмнө татвар төлөгчийн татварын албанд бүртгэлтэй утас цахим шуудангийн хаягаар татвар төлөгчдөд урьдчилан мэдэгдэж тайлбар санал гаргах боломжийг олгоно. Түүнчлэн уг хугацаанд хуульд заасан үндэслэл хангагдсан тохиолдолд татвар төлөгчийн мэдээллийг олон нийтэд мэдээлэхгүй байх зохицуулалтыг тусгаж тодорхой болголоо.

5.Эрх зүйн байдлыг тодорхой хангасан эсэх тухайд зөрчлөө арилгасан бол мэдээллийг устгах эсэх, ийнхүү устгах нөхцөл журмыг тодорхой тусгаагүй гэсэн бол тохирсон байх зарчмыг хангасан эсэх тухайд эрхийг хязгаарлах хуулийн үндэслэл нөхцөл үгүй болсноор нийтэд дэлгэсэн мэдээллийг устгах хуулийн хязгаарлалт тогтоогоогүй нь үндсэн эрхийн хязгаарлалт явцуу хүрээтэй байх, үндсэн эрхийг хамгийн бага хэмжээнд хязгаарлах зайлшгүй байх зарчимд нийцэхгүй байна гэсэн байна аа.

Үүнтэй холбогдуулан санхүүгийн баримтыг хуурамчаар үйлдсэн эсэхийг хууль хяналтын байгууллагын эсвэл шүүхийн шийдвэрийн эцэслэн тогтоосон бол холбогдох шийдвэр, түүнчлэн эрэн сурвалжлагдаж байгаа татвар төлөгч сайн дураар оршин суугаа газраа тодорхойлон эсвэл хууль хяналтын байгууллага олж тогтоосноор эрэн сурвалжлах нөхцөл арилсан талаарх мэдээллийг үндэслэн цахим

хуудсанд нийтэлж олон нийтэд мэдээлсэн татвар төлөгчийн мэдээллийг мэдээллийн жагсаалтаас хасах зохицуулалтыг тусгаж өглөө.

6.Эрх зүйн тодорхой байдлыг хангасан эсэх тухайд мэдээллийг дэлгэх эрх бүхий этгээдийг татварын алба гэж ерөнхий байдлаар хуульчилсан байна аа. Татварын алба гэдэг нь нэр томъёоны хүрээнд авч үзэх юм бол татварын байцаагч бүр ийм эрх эдлэхээр ойлгогдож байгаа болно. Үүнтэй холбогдуулан татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага уг зохицуулалтад хамаарах мэдээллийг олон нийтэд мэдээлэх зохицуулалтыг тусгалаа.

7.Эрх зүйн байдлыг хангасан эсэх тухайд нийтэд мэдээлж болно гэж заасан нь дээр дурдсан урьдач нөхцөлийг бүгдийг хангаж татварын хууль тогтоомж зөрчсөн, улмаар оргон зайлж эрэн сурвалжлагдаж байгаа татвар төлөгчийг нийтэд мэдээлэх эсэхийг татварын албаны холбогдох албан тушаалтан нь өөрийн үзэмжээр шийдвэрлэх эрсдэлийг бүрдүүлжээ.

Уг асуудлын шийдвэрлэх эрхийг түүний үзэмжид үлдээсэн нь хуулийн дээрх зохицуулалтыг дур мэдэж эсвэл ялгамжтай байдлаар хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж урвуулан ашиглах боломжийг үүсгэсэн гэж үзэхээр байна гэсэн бол тохирсон байх зарчмыг хангасан эсэх тухайд эрхийн хязгаарлалтыг албан тушаалтны дур мэдэлд үлдээж урьдач нөхцөлийг хангасан ч нийтлэхгүй байж болохоор хэт өргөн хүрээтэй хязгаарласан нь үндсэн эрхийн хязгаарлалт явцуу хүрээтэй байх, үндсэн эрхийг хамгийн бага хэмжээнд хязгаарлах зайлшгүй байх зарчимд нийцэхгүй байна гэж үзсэн.

Үүнтэй холбогдуулан уг зохицуулалтад заасан нөхцөл бүрдсэн нөхцөлд тухай бүрд нь олон нийтэд мэдээлж байх зохицуулалтыг тусгалаа.

8.Хуулийн төслийг бусад хууль тогтоомжтой нийцүүлэн боловсруулж төслийн зүйл хоорондын нийцлийг хангасан болно оо.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Ц.Даваасүрэн:** Ажлын хэсгийн ахлагч Заяамул гишүүнд баярлалаа. Ажлын хэсэг богино хугацаанд сайн ажилласан байна. Сайн, урт дүгнэлт, танилцуулга бэлдсэн байна.

Ингээд өнөөдрийн хуралдаанд оролцож байгаа Татварын Ерөнхий газрын албан тушаалуудыг танилцуулаадахъя Т.Тогосмаа Татварын Ерөнхий газрын Хуулийн хэрэгжилтийг хангах газрын дарга, Л.Мөнхтуул Татварын ерөнхий газрын Олон улсын татварын хэлтсийн дарга, Б.Буяннэмэх Татварын ерөнхий газрын Татвар төлөгчидтэй харилцах газрын дарга гэсэн ийм хүмүүс оролцож байна аа.

Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэхээр байгаа. Ингээд зүйл бүрээр хэлэлцэж эхэлье ээ.



Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай та бүхэнд тараасан хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна.

1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна.

2 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна.

3 дугаар зүйлтэй холбогдуулаад зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна аа. Ингээд Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Горимын санал. Заябал гишүүн горимын санал гаргаж байна.

**Б.Заяабал:** Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар зарчмын зөрөөтэй саналын томъёолол гараагүй тул Дэгийн тухай хуулийн 39.24-д заасны дагуу хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах шат руу шилжүүлэх горимын саналыг гаргаж байна. Дэмжиж өгнө үү.

**Ц.Даваасүрэн:** Тэгвэл Заяабал гишүүний гаргасан төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах шат руу шилжүүлэх горимын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Заяабал гишүүн нэгдсэн хуралдаанд танилцуулна.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулж дууслаа.

Баярлалаа гишүүд ээ. Өнөөдрийн хурал үүгээр дууслаа.

Батжаргал гишүүнийг дэмжсэнээр авах юм байна протоколд. Цогтбаатар гишүүн, Батлут ч гэсэн. Ингээд энэ 3 гишүүнийг дэмжсэнээр авна шүү протоколд. Баярлалаа гишүүд ээ. Хуралдаан хаагдлаа.

18.20 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА